



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

Нийслэлийн Засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7799 0101

Цахим шуудан: ubhd@emg.ub.gov.mn
Цахим хуудас: www.ubhealth.mn

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

2023.06.19 № 10-13-01/016/2023

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг
хангаж ажиллах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Боловсрол шинжлэх ухааны яамны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нарын хамтран баталсан 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн "Эмнэлгүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" 10-00/17 дугаартай удирдамжийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, С.Зоригийн гудамжинд байрлах Улсын нэгдүгээр төв эмнэлгийн үйл ажиллагаанд 2023 оны 06 дугаар сарын 07-ний өдөр "Төрийн хяналт шалгалтын тухай", Зөвшөөрлийн тухай". "Эрүүл мэндийн тухай", "Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай", Цөмийн энергийн тухай, Цацрагийн аюулгүйн норм, Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, Засгийн газрын 2011 оны "Нийтлэг журам батлах тухай" 311 дүгээр тогтоол болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын, хэрэгжилтэд Боловсрол соёл шинжлэх ухааны яамны хэрэгжилтэд Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Түмэндэмбэрэл, А.Энхбаатар, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Чанар, эрүүл мэндийн хяналт зохицуулалтын хэлтсийн Эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч Т.Улзмаа, нар 2023 оны 06 дугаар сарын 07-ноос 06 дугаар сарын 15-ны өдрүүдэд Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга н. Одсүрэн, цацрагийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Г.Мөнхцэцэгийг байлцуулан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг 10.1.1 кодтой "Эмнэлгийн оношилгоо эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар үнэлэхэд 13.8% буюу бага эрсдэлтэй, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг 10.1.11 кодтой "Эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар үнэлэхэд 6.8 % буюу бага, Цөмийн болон цацрагийн аюулгүй ажиллагааны эрсдэлийг 03/8.2-5 кодтой "Цөмийн онош зүйн цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын

1150500174

хуудас"-аар Иод 131, Иод 125, Спект-СТ зэрэг объектуудыг үнэлж, цацрагийн эрүүл ахуй-дозиметрийн хэмжилтийг хийлээ.

Хяналт шалгалтаар дараах алдаа дутагдал илэрлээ. Үүнд:

ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээг гардан үзүүлж байгаа их эмч, сувилагчийн харьцаа стандарт заагдсан хэмжээнээс бага (07:1, сувилагч дутагдалтай) байгаа нь Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 6330:2017 стандартын А хавсралтын А1.3 дах заалтыг;

2.Чанарын менежерээр /Дотор хариуцсан/ нийтлэг шаардлага хангаагүй мэргэжилтэн томилсон байгаа нь Монгол улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 116/А/565 тоот тушаалын хавсралтын "Эмнэлгийн тусламж үйлчилгээний, чанар аюулгүй байдлын албаны дүрмийн 2.11 дахь хэсгийг;

3. Үйлчлүүлэгчийг зөв таньж,тодруулах журмыг мөрдөж ажиллаагүй байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Журам батлах" тухай А/352 тоот тушаалыг;

4. Цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөл нь цус усан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулж удирдлага арга зүйгээр хангаж ажлыг зохион байгуулаагүй байгаа нь /Хуралдаагүй/ Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 6330:2017 стандартын 12 дугаар зүйлийн 12.7.1 дэх заалтыг;

5. Сэргээн засах тусламж үйлчилгээг баг (хөдөлгөөн засал, хэл засал, хөдөлмөр)-аар үзүүлэхгүй байгаа нь Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 6330:2017 стандартын 12 дугаар зүйлийн 12.3.1, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 502 тоот тушаалын 6 дугаар зүйлийн 6.1.5 дах заалтыг;

6. Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг хэвтүүлэн эмчлэх эмчилгээний хэлбэрээр тусламж үйлчилгээг үзүүлээгүй, Монголын уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлэх зааврын хэрэгжилт хангалтгүй байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн "Монголын уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай" 378 тоот тушаалын 6 дугаар заалтыг;

7. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын үзлэг, шалгалт, засвар, үйлчилгээ, тохиргоог үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу хийж техник ашиглалтын паспортод тэмдэглээгүй нь Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 6330:2017 стандартын 14 дэх хэсгийн 14.3.3 дах заалтыг;

ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

1.Цөмийн эмчилгээ, оношилгооны өрөөнүүд дүрмийн шаардлага хангасан зориулалтын агааржуулалтын системгүй нь Цөмийн энергийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3 дахь заалтыг;

2.Цацрагтай ажиллагч болон цацрагийн хяналтын ажилтныг 2 жил тутамд цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын сургалтад бүрэн хамруулаагүй нь Цөмийн энергийн тухай

хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.7, Цацрагтай холбогдолтой үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын цацрагийн аюулгүйн албаны дүрмийн 1.8, Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрмийн 3.13.7(8) дахь заалтыг;

3.Цацрагийн үүсгүүр хадгалах болон тугналт хийх өрөөний цацрагийн хамгаалалт, аюулгүй байдал нь шаардлага хангахгүй байгаа нь Цөмийн энергийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалтыг;

4.Цацрагтай ажиллагч буюу хэвийн бус нөхцөлд хамрагдах ажиллагчдад хүнсний нэмэлт бүтээгдэхүүн олгодоггүй нь Цөмийн энергийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.8 дахь, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.9 дэх заалтыг;

5.Цацрагийн үүсгүүрээр эмчилгээ, оношилгоо хийх цацрагийн хамгаалалт, чанарын баталгаажилтын хөтөлбөргүй нь Цөмийн энергийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтыг;

6.Цацрагийн үүсгүүр бүхий тоног төхөөрөмжид тохируулга, чанарын хяналтын хэмжилтийг тогтмол хийдэггүй нь Цөмийн энергийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2 дахь заалтыг;

7.Дотоод хяналтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийдэггүй нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалт, Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрмийн 3.8.1 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна.

Иймд дээрх алдаа, дутагдлыг арилгах зорилгоор төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8 дахь хэсэгт заасны дагуу улсын байцаагчийн эрхийнхээ хүрээнд **ШААРДАХ НЬ:**

ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

1. Үйл ажиллагааны онцлогт тохирсон орон тоог стандартад заагдсан хэмжээнд бүрдүүлж ажиллах;
2. Чанарын менежерээр /Дотор хариуцсан/ шаардлага хангасан мэргэжилтэнг томилж ажиллуулах;
3. Эмч, мэргэжилтэн нар үйлчлүүлэгчийг зөв таньж тодруулах журмыг мөрдөж ажиллах;
4. Цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах;
5. Сэргээн засах тусламж үйлчилгээг баг (хөдөлгөөн засал, хэл засал, хөдөлмөр)-аар үзүүлэх;
6. Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг хэвтүүлэн эмчлэх эмчилгээний хэлбэрээр тусламж үйлчилгээг үзүүлэх;
7. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын үзлэг, шалгалт, засвар, үйлчилгээ, тохиргоог үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу хийж, техник ашиглалтын паспортод тэмдэглэл хөтлөх;

ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

1.Цөмийн онош зүйн тасгийг бүхэлд нь зориулалтын агааржуулалтын системтэй болох;

2.Цацрагтай ажиллагч болон цацрагийн хяналтын ажилтныг 2 жил тутамд цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын сургалтад бүрэн хамруулах;

3.Цацрагийн үүсгүүр бүхий өрөөний цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулж, зөвшөөрөлгүй хүн нэвтрэхээс бүрэн хамгаалах;

4.Цацрагтай ажиллагчдад хэвийн бус нөхцөлийн хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг тогтмол олгох;

5.Цацрагийн үүсгүүрээр эмчилгээ, оношилгоо хийх цацрагийн хамгаалалт, чанарын баталгаажилтын хөтөлбөр боловсруулж, байгууллагын даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

6.Цацрагийн үүсгүүр бүхий тоног төхөөрөмжид тохируулга, чанарын хяналтын хэмжилт, чанарын баталгаажилтын хэмжилтийг жил бүр тогтмол хийлгэх;

7.Дотоод хяналтын удирдамж төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хяналт тавьж, ажиллах;

Дээрх албан шаардлагыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг 2023 оны 08 дугаар 25-ны өдрийн дотор тус газрын Чанар, эрүүл мэндийн хяналт зохицуулалтын хэлтэс, Боловсрол соёл, шинжлэх ухааны яамны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газарт чиглэл албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

Албан шаардлагыг биелүүлээгүй, хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтуудын дагуу хариуцлага тооцохыг мэдэгдье.

Улсын байцаагчдын хамтарсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

Тайлбар.....

ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Т.УЛЗМАА

ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ




Т.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



А.ОНХБААТАР

АЛБАН ШААРДЛАГА ХҮЛЭЭН АВСАН:
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ХИШИГЖАРГАЛ

Жич: Энэ тэмдэглэл нь удирдамжийн хамт хүчинтэй байна.

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Дугаар 10-00/17

Үлкенбастар жет

/аймаг, нийслэл, сүм, дүүрэг/

2023 оны 06 сарын 07

Улсын байцаагчийн дугаар 03-00-01/106

Шалгуулагч этгээдийн нэр, регистрийн дугаар, хаяг, байршил, холбоо барих утас:

[illegible]

Хяналт шалгалтын явц: Монгол улсын хамт олонтой хийх

[illegible]

Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал: *төрийн газрын 144 нэг-136 нэг-144*

группы С1 (AS, SO, ST, SE): группы с низким потенциалом развития - для них характерно отсутствие каких-либо талантов, группой управляет один человек, группа не имеет цели, не знает, что такое сотрудничество, не имеет своего мнения, не имеет своего имени, не имеет своего будущего.

$115.1214 \times 24.11794 = 2781.2111$ $2001.4111 \times 11.1111 = 2222.2222$
 $- 115.1214 \times 24.11794 = -2781.2111$ $2001.4111 \times 11.1111 = 2222.2222$
 $115.1214 \times 24.11794 = 2781.2111$ $2001.4111 \times 11.1111 = 2222.2222$

Удсын байгаагчийн санал дүгнэлт: *Удсын байгаагчийн санал дүгнэлт: 2019.01.01-2019.01.01*

3.13.7(2): 3.8.1 дагын үсэг нь зөвхөн 8 дагын

[illegible]

carina

Шалгуулагч этгээдийн санал, хүсэлт:

Төсөл аяктап тауарлар мен құралдарды қайтармақ

11. 11. 1985

Тэмдэглэл үйлдсэн: М. Мунж 22.10.2020

/Шалгасан/ /Албан тушаал/ /Гарын үсэг, тэмдэг/ /Гарын үсгийн тайлал/

Тэмдэглэлтэй танилцсан: *Дундговь* / *Б. Хуучинжав*

Тэмдэглэлтэй ганилцсан.

/Шалгуулагч этгээд/ /Албан түшаал/ /Гарын үсэг, тэмдэг/ /Гарын үсгийн тайлал/

A. arpa Үрб., төмөсү; *A. arpa* Үрбдүн тизмасы;

Шалгуулагч этгээд гарын үсэг зурахаас татгалзсан тухай тэмдэглэл:

.....

.....

Жич: Энэ тэмдэглэл нь удирдамжийн хамт хүчинтэй байна.

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Дугаар _____

જાનો. અંક

/аймаг, нийслэл, сум, дүүрэг/

2023. оны 06 сарын 15 -ны өдөр

Улсын байцаагчийн дугаар 10-13-01/016

Шалгуулагч этгээдийн нэр, регистрийн дугаар, хаяг, байршил, холбоо барих утас:

[illegible]

Хяналт шалгалтын явц:

Хяналт шалгалтын явц:

Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал:

Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал:

Улсын байцаагчийн санал, дүгнэлт:

[illegible]

Шалгуулагч этгээдийн санал, хүсэлт:

[illegible]

Тэмдэглэл үйлдсэн:

/Шалгасан/

/Албан түшаал/

Тэмдэглэлтэй танилцсан:

зокеци

Шалгуулагч этгээд/

/Албан түшаал/

Шалгуулагч этгээд гарын үсэг зурахаас татгалзсан тухай тэмдэглэл:



/Гарын үсгийн тайлал/

З. Левицкая.

/Гарын үсгийн тайлал/